



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2024 оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3, 14 дүгээр зүйлийн 14.2.1, 14.2.2, 14.2.3, 14.2.4, 14.2.9, 14.2.13 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн гуравдугаар хавсралт “Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам”, наймдугаар хавсралт “Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох, актуарын стандарт, үнэлгээ болон актуарчийн хяналт шалгалт хийх, тайлан гаргах журам”, арван нэгдүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчоос тайлан, мэдээ, өргөдөл гаргах заавар”-ыг энэхүү тогтоолын 1, 2, 3 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн дараах хавсралтуудад доор дурдсан агуулга бүхий заалтуудыг нэмсүгэй:

2.1. нэгдүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-д

1/“7.1.12. Даатгалын хураамжийн зохих хэсэг нь тодорхой хөрөнгө оруулалтад даатгуулагчийн хүсэл сонирхол болон гэрээнд заасан нөхцөлийн дагуу байршдаг урт хугацааны даатгалын бүтээгдэхүүн /цаашид хөрөнгө оруулалттай холбоотой даатгалын бүтээгдэхүүн гэх/ нь дараах онцлог, шинж чанартай байна. Үүнд:”

2/“7.1.12.а. гэрээний үргэлжлэх хугацаанд даатгуулагч нь даатгалын компанийн ашгаас ноогдол ашиг авах нөхцөл бүхий урт хугацааны даатгалын гэрээ буюу Хувь оролцоотой гэрээ нь уг бүтээгдэхүүнд хамаарна.”

3/“7.1.12.б. үндэслэл бүхий тооцоо, судалгаанд суурилах, эрсдэлийг хэт төвлөрүүлэхгүй байх, хөрвөх чадварын зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, даатгуулагчид шаардлагагүй зардал, эрсдэл үүсгэхээс зайлсхийх зарчмыг баримтлан хөрөнгө оруулалтын өгөөж /баталгаат, зорилтот гэх мэт/, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбогдох аливаа төлбөр, хураамж, хөрөнгө оруулалтын багц дахь хөрөнгө оруулалтын хэрэгсэл, тэдгээрийн эзлэх хувь хэмжээ, хязгаар зэрэг үзүүлэлтүүдийг тодорхойлсон байх;”

4/“7.1.12.в. энэ журмын 7.1.5-д заасан журамд хөрөнгө оруулалт хийх хязгаар, хориглох зүйлийг урьдчилан тодорхойлж, хөрөнгө оруулалтын эрсдэлийн зохистой удирдлага, эрсдэлээс сэргийлэх арга, хэрэгслийн талаар тусгасан байх.”

5/“7.1.12.г.даатгуулагч, даатгалын гэрээ байгуулж буй этгээд нь хөрөнгө оруулалтад учирч болох эрсдэлийг ойлгох чадамжтай байх буюу Иргэний эрх зүйн бүрэн чадамжтай этгээд байх.”

6/“7.2.3.к.Хөрөнгө оруулалттай холбоотой даатгалын бүтээгдэхүүний хөрөнгө оруулалтын багц дахь хөрөнгө оруулалтын хэрэгсэл, тэдгээрийн онцлог шинж чанар, учирч болзошгүй эрсдэл болон энэ журмын 7.1.12.б-д заасан үзүүлэлтүүдийн мэдээлэл.”

2.2.дөрөвдүгээр хавсралт “Даатгалын нөөц санд болон албан журмын даатгалын санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ, түүнийг хөрөнгө оруулалтад байршуулахад тавигдах нөхцөл, шаардлага”-д

1/“2.5.Даатгагч орлогод тооцоогүй хураамжийн нөөцийг бэлэн мөнгө, банкны харилцах, хадгаламж, хадгаламжийн сертификат болон даатгалын хураамжийн авлага хэлбэрээр байршуулж болох бөгөөд бэлэн мөнгөнд уг нөөцийн 2 хүртэл хувиар байршуулна.”

2/“2.6.Давхар даатгагч Алдагдлаас хамгаалах сангийн 1/3 хэсгийг Монголбанкнаас тусгай зөвшөөрөл авсан, Даатгалын тухай хуулийн 4.1.12-т заасан холбогдох этгээдэд хамаарах банкнаас бусад банкинд байршуулах бөгөөд нэг банкинд байршуулах мөнгөн хөрөнгийн дээд хязгаар нь дээрх мөнгөн дүнгийн 25 хувиас хэтрэхгүй байна.”

3/“2.7.Давхар даатгагч энэ журмын 2.6-д заасан Алдагдлаас хамгаалах сангийн үлдэх 2/3 хэсгийг дор дурдсан хувь хэмжээгээр хөрөнгө оруулалтад байршуулж болно:”

4/“2.7.1.Банкны хадгаламж: 100 хүртэл хувь (нэг банкинд 20 хүртэл хувь);”

5/“2.7.2.Банкны харилцах дансанд байршуулах: 100 хүртэл хувь (нэг банкинд 20 хүртэл хувь);”

6/“2.7.3.Засгийн газрын өрийн бичиг: 100 хүртэл хувь;”

7/“2.7.4.Төв банкны үнэт цаас: 60 хүртэл хувь;”

8/“2.7.5.Орон нутгийн засаг захиргааны бонд: 20 хүртэл хувь;”

9/“2.7.6.Үл хөдлөх хөрөнгөөр барьцаалсан үнэт цаас 20 хүртэл хувь;”

10/“2.7.7.Банкны хадгаламжийн сертификат: 10 хүртэл хувь;”

11/“2.7.8.Компанийн бонд: 10 хүртэл хувь (нэг компанид 5 хүртэл хувь);”

12/“2.7.9.Санхүүгийн болон үйл ажиллагааны лизинг: 5 хүртэл хувь;”

13/“2.7.10.Даатгалын тухайн хуулийн 4.1.12-т заасан “холбогдох этгээд”-ээс бусад этгээдэд үл хөдлөх хөрөнгө барьцаалсан арилжааны богино хугацаат (нэг жил хүртэл) зээл 5 хүртэл хувь;”

14/“2.7.11.Үл хөдлөх хөрөнгө: 10 хүртэл хувь (үндсэн үйл ажиллагаа явуулдаг ажлын байрнаас бусад).”

15/“2.8.Давхар даатгагч энэ журмын 2.7.11-д заасны дагуу үл хөдлөх хөрөнгөнд хөрөнгө оруулсан нөхцөлд хөрөнгийн үнэлгээг Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн дагуу хийлгэсэн байна.”

16/“3.1.1.Энэ журмын 2.1.1-д заасан нөөц сангийн хөрөнгийн байршлын тайланг энэ журмын 1 дүгээр хавсралтын дагуу санхүүгийн тайлангийн хамт улирал бүр;”

17/“3.1.2.Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн байршлын тайланг энэ журмын 2 дугаар хавсралтын дагуу санхүүгийн тайлангийн хамт улирал бүр;”

18/“3.1.3.Давхар даатгагч нь Алдагдлаас хамгаалах сангийн хөрөнгийн байршлын тайланг энэ журмын 3 дугаар хавсралтын дагуу санхүүгийн тайлангийн хамт улирал бүр;”

19/“3.1.4.Урт хугацааны даатгагч нь Даатгалын багц дүрмийн гуравдугаар хавсралт “Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан, бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам”-д заасан “Даатгуулагчийн хөрөнгө оруулалтын сан”-гийн хөрөнгийн байршлын тайланг энэ журмын 4 дүгээр хавсралтын дагуу санхүүгийн тайлангийн хамт улирал бүр.”

3.Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн дөрөвдүгээр хавсралт “Даатгалын нөөц санд болон албан журмын даатгалын санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ, түүнийг хөрөнгө оруулалтад байршуулахад тавигдах нөхцөл, шаардлага”-д энэ тогтоолын 4, 5, 6 дугаар хавсралтад заасан агуулга бүхий 2, 3, 4 дүгээр хавсралтыг тус тус нэмсүгэй.

4.Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн дараах хавсралтуудын нэр бүхий заалтуудыг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

4.1.хоёрдугаар хавсралт “Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ын

1/“2.13.3.Энэ журмын есдүгээр хавсралтад заасан урт хугацааны даатгалын андеррайтингийн эрсдэл тус бүрийн хувьд энэ журмын наймдугаар хавсралтад заасны дагуу даатгалын хэлбэрээр багцлан, түүнд хамаарах Бүтээгдэхүүний бүлгээр ангилан эрсдэлд суурилсан хөрөнгийн дүнг тодорхойлох ба Даатгалын багц дүрмийн гуравдугаар хавсралт “Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан, бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам”-д заасан “Даатгуулагчийн хөрөнгө оруулалтын сан”-гийн дүн үүнд хамаарахгүй. Тус эрсдэлд суурилсан хөрөнгийн дүнг энэ журамд заасан дараах шаардлагыг хангасан, даатгагч өөрийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүний онцлогт тохируулан боловсруулсан аргачлалын дагуу тооцоолох бөгөөд аргачлалыг жил бүрийн 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Хороонд ирүүлж танилцуулсны үндсэн дээр өөрчилж болно. Үүнд:”

2/“2.14.2. Урт хугацааны даатгагчийн хувьд “ҮА” үзүүлэлтийг даатгалын нөөц сангуудын нийлбэр дүн болон хөрөнгө оруулалттай холбоотой гэрээнд хамаарах зардлын дүнг ашиглан дараах томъёогоор тооцно:

$$ҮА = НС + 0.25 * ХОЗ. \text{ Үүнд:}$$

НС – даатгалын нөөц сангуудын нийлбэр дүн (Даатгагчийн санхүүгийн байдлын тайлангийн ОТХН, нөхөн төлбөрийн нөөц сан, хөрөнгө оруулалтын хураамжийн нөөц сангийн дүн);

ХОЗ – хөрөнгө оруулалттай холбоотой гэрээнд хамаарах зардлын дүн /Тухайн хөрөнгө оруулалтын өртгийн дүн үүнд хамаарахгүй/.”

4.2.дөрөвдүгээр хавсралт “Даатгалын нөөц санд болон албан журмын даатгалын санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ, түүнийг хөрөнгө оруулалтад байршуулахад тавигдах нөхцөл, шаардлага”-ын

1/“1.3.Урт хугацааны даатгагч даатгалын нөөц сангийн хөрөнгө оруулалтад байршуулах дүнг Орлогод тооцоогүй хураамжийн нөөц, Учирч болзошгүй хохирлын нөөц сан, Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан, Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан, Хөрөнгө оруулалтын хураамжийн нөөц сан тус бүрийн санхүүгийн байдлын тайлангийн харгалзах дүнгүүдийн нийлбэрээс нөөц сан тус бүр дэх давхар даатгагчид ногдох хэсгийг хассан дүнгээр тодорхойлно.”

2/“3.1.Даатгагч нь дараах тайлан, мэдээллийг заасан хугацаанд Хороонд ирүүлнэ. Үүнд:”

5.Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн дөрөвдүгээр хавсралт “Даатгалын нөөц санд болон албан журмын даатгалын санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ, түүнийг хөрөнгө оруулалтад байршуулахад тавигдах нөхцөл, шаардлага”-ын 1.2 дахь хэсгийн “даатгалын нөөц санг” гэснийг “даатгалын нөөц

сангийн хөрөнгө оруулалтад байршуулах дүнг Орлогод тооцоогүй хураамжийн нөөц,” гэж, 1.4 дэх хэсгийн “даатгалын нөөц санг” гэснийг “даатгалын нөөц сангийн хөрөнгө оруулалтад байршуулах дүнг Орлогод тооцоогүй хураамжийн нөөц,” гэж тус тус өөрчлөн найруулсугай.

6. Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн хавсралтуудад энэ тогтоолоор оруулсан нэмэлт, өөрчлөлтүүдийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

7. 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн гуравдугаар, наймдугаар болон арван нэгдүгээр хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

8. Энэ тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан журмын 10.1.1, 10.1.2 дахь заалтад заасан арга хэмжээг 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн дотор, 10.1.3-10.1.7 дахь заалтад заасан арга хэмжээг 2025 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн дотор хэрэгжүүлж, арга хэмжээний биелэлт, үр дүнгийн талаар Хороонд мэдэгдэхийг даатгагч нарт үүрэг болгосугай.

9. Даатгагчийн 2024 оны тайлант хугацаанд хамаарах актуарын хяналт шалгалтын үр дүн болон даатгалын нөөц сангийн шинэчилсэн зохицуулалтын хүрээнд гарсан өөрчлөлт, ашиглагдах дата өгөгдөл, таамаглал, аргачлал, ирээдүйн үйл ажиллагааны төсөөлөл зэрэг үзүүлэлтүүдийг багтаасан Актуарын хяналт шалгалтын тайланг энэ тогтоолын 23 дугаар хавсралтаар баталсан Актуарын хяналт шалгалтын тайлангийн стандарт загварын дагуу боловсруулан 2025 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн дотор Хороонд хүргүүлэхийг даатгалын компаниудын актуарч нарт үүрэг болгосугай.

10. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны 2024
оны ... дугаар сарын ...-ны өдрийн
... дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

Санхүүгийн зохицуулах хорооны
2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан
“Даатгалын багц дүрэм”-ийн гуравдугаар хавсралт

ДААТГАЛЫН НӨӨЦ САН, АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН САН БОЛОН БУСАД САНГ БҮРДҮҮЛЭХ, ХУВААРИЛАХ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь ердийн, урт хугацааны даатгагч болон давхар даатгагч (цаашид “даатгагч” гэх) даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ноос хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2.Даатгагч энэ журамд заасан ангилал болон аргачлалаар даатгалын нөөц сан, бусад санг бүрдүүлэх бөгөөд энэ нь даатгуулагчтай байгуулсан даатгалын гэрээнээс үүсэх хариуцлагыг байнга хангахуйц хэмжээнд байна.

1.3.Даатгагч даатгалын эрсдэлийн багцаа шилжүүлэх, эсхүл Хорооны өгсөн үүрэг даалгаврын дагуу үйл ажиллагааг нь түр зогсоох, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох зэрэг нөхцөлд даатгуулагчийн өмнө хүлээх эрсдэлийг бүрэн тайлагнах нөхцөлийг хангах зорилгоор календарийн аливаа өдрөөр даатгалын нөөц сангийн тайлан гаргах боломжийг бүрдүүлсэн байна.

1.4.Даатгалын нөөц санг бүрдүүлэх мөнгөн хөрөнгийн бүрэлдэхүүн хэсэг болох даатгалын хураамжийн орлого болон даатгалын нөөц санд төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг барьцаалан даатгагч зээл авч болохгүй.

Хоёр. Даатгалын нөөц санг бүрдүүлэх ерөнхий удирдамж

2.1.Даатгагч нь дараах зарчмыг баримтлан тодорхойлсон таамаглал, аргачлалын дагуу даатгалын нөөц санг бүрдүүлнэ. Үүнд:

2.1.1.даатгалын бүтээгдэхүүн болон түүнтэй холбогдох эрсдэлийн шинж чанарт нийцсэн байх;

2.1.2.энэ журмын нэгдүгээр хавсралтад заасан нэг бүтээгдэхүүний бүлэгт багтах төрөл бүрийн бүтээгдэхүүний хувьд таамаглал, аргачлал ижил байх;

2.1.3.энэ журмын 9.1-д заасны дагуу даатгалын нөөц санг тооцоолох таамаглал, аргачлалд өөрчлөлт оруулахаас бусад тохиолдолд нэг тайлант үеэс дараагийн тайлант үеийн хооронд ижил бүтээгдэхүүний хувьд таамаглал, аргачлал нэг адил байх;

2.1.4.даатгалын бүх гэрээний хувьд хариуцлага, өр төлбөрийг үнэн зөв, үндэслэлтэй тооцож, хүлээн зөвшөөрсөн байх;

2.1.5.даатгалын гэрээнд тусгагдсан баталгаат эсхүл амласан өгөөж /бенефит/, нөхөн төлбөртэй уялдсан байх;

2.1.6. Даатгалын багц дүрмийн наймдугаар хавсралт “Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох, актуарын стандарт, үнэлгээ болон актуарчийн хяналт шалгалт хийх, тайлан гаргах журам”-д заасан Актуарын стандартыг баримтлах.

2.2. Даатгалын нөөц санг Хорооноос актуарын эрх авсан актуарч тооцоолно.

2.3. Актуарч аливаа таамаглал, аргачлалд хамгийн багадаа сүүлийн 3-аас 5 жилийн хугацаан дахь даатгагчийн болон салбарын /шаардлагатай тохиолдолд/ статистик өгөгдөл, мэдээллийг ашиглана (даатгагч 3-аас доош жилийн туршлагатай бол салбарын болон давхар даатгагчийн өгөгдлүүдийг ашиглаж болно).

2.4. Статистик өгөгдөл, мэдээллийн хангалттай, найдвартай байдлыг хангах зорилгоор даатгагч нь энэ журмын хоёрдугаар хавсралтын дагуу дараах бүртгэлүүдийг хөтөлж, баримтжуулах ба эдгээр бүртгэлд суурилан даатгалын нөөц санг бүрдүүлнэ. Үүнд:

2.4.1. даатгуулагчтай байгуулсан даатгалын гэрээний бүртгэл;

2.4.2. даатгалын тохиолдол, нэхэмжлэлийн бүртгэл;

2.4.3. даатгалын нөхөн төлбөрийн бүртгэл;

2.4.4. давхар даатгагчид даатгуулсан даатгалын гэрээ, холбогдох нөхөн төлбөрийн бүртгэл.

2.5. Даатгагч энэ журмын гуравдугаар хавсралтын дагуу боловсруулсан даатгалын нөөц санг тооцож, бүрдүүлэх Дотоод журамтай байна.

2.6. Даатгагч даатгалын бүтээгдэхүүн болон түүний эрсдэлийн шинж чанараас хамааран даатгалын хэлбэрийн хүрээнд дараах нөөц сангуудыг бүрдүүлнэ. Үүнд:

2.6.1. Ердийн даатгагчийн хувьд Орлогод тооцоогүй хураамжийн нөөц (цаашид ОТХН гэх), Учирч болзошгүй хохирлын нөөц сан (цаашид УБХНС гэх), Нэхэмжлэлийн нөөц сан, Тусгай нөөц сан;

2.6.2. Урт хугацааны даатгагчийн хувьд ОТХН, УБХНС, Нэхэмжлэлийн нөөц сан, Хөрөнгө оруулалтын хураамжийн нөөц сан, Даатгуулагчийн хөрөнгө оруулалтын сан;

2.6.3. Давхар даатгагчийн хувьд ОТХН, УБХНС, Нэхэмжлэлийн нөөц сан, Алдагдлаас хамгаалах сан;

2.6.4. Хэрэв давхар даатгагч нь Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн дагуу малын давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгайлсан чиг үүрэгтэй бол энэ журмын 2.6.3-д заасан нөөц сангуудаас гадна Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд заасан санг холбогдох журмын дагуу.

Гурав. Орлогод тооцоогүй хураамжийн нөөц

3.1. Энэ журмын нэгдүгээр хавсралтад заасан Бүтээгдэхүүний 1, 4-р бүлгийн хувьд ОТХН-ийг бүрдүүлнэ.

3.2. Даатгалын гэрээний хувьд ОТХН-ийг “хувь тэнцүүлсэн арга”-аар дараах томъёог ашиглан тооцно:

$$ОТХН_i = (ДНХ_i - ДБ_i) * \frac{X_i}{H_i}$$

Үүнд:

$ОТХН_i$ = i дугаар даатгалын гэрээний ОТХН;

$ДНХ_i$ = i дугаар даатгалын гэрээний нийт хураамжийн орлого;

$ДБ_i$ = i дугаар даатгалын гэрээний даатгалын хураамжийн буцаалт

$X_i = i$ дугаар даатгалын гэрээний хүчинтэй байх үлдсэн хугацаа/өдрөөр/ бөгөөд үүнийг гэрээний нийт хугацаанаас тухайн гэрээний тайлагналын өдөр хүртэл үргэлжилсэн хугацааг хасч тооцно;

$N_i = i$ дугаар даатгалын гэрээний нийт үргэлжлэх хугацаа.

i - орлогод тооцоогүй хураамжийн нөөц тооцогдсон даатгалын гэрээний дугаар

3.3. Нийт ОТХН нь даатгалын гэрээ тус бүрээр байгуулсан ОТХН-ийн нийлбэртэй тэнцүү бөгөөд дараахь томъёогоор тооцно.

$$ОТХН_t = \sum_{i=1}^n ОТХН_i$$

. Үүнд:

$ОТХН_t$ - t хугацаан дахь нийт ОТХН

n - ОТХН тооцсон даатгалын гэрээний нийт тоо

3.4. Буцаасан даатгалын хураамжийг хууль тогтоомжийн дагуу даатгалын гэрээний хугацаа дуусахаас өмнө даатгагчаас даатгуулагчид тухайн гэрээний үлдэх хугацаанд ногдуулан буцаан олгосон хураамжаар тодорхойлно.

3.5. Тайлагналын өдрөөр даатгалын хариуцлага гэрээний дагуу дууссан, эсхүл шинээр даатгалын хариуцлага нэмэгдсэн зэрэг шалтгаанаар ОТХН-ийн үлдэгдлийг тооцоолсны дараа тус нөөцийг өмнөх тайлант хугацааны дүнгээс бууруулах эсвэл нэмэгдүүлнэ.

Дөрөв. Учирч болзошгүй хохирлын нөөц сан

4.1. Энэ журмын нэгдүгээр хавсралтад заасан Бүтээгдэхүүний 2, 3, 5-р бүлгийн хувьд УБХНС-г энэ журмын 4.2-т заасны дагуу бүрдүүлнэ.

4.2. УБХНС-г тайлагналын өдрөөрх энэ журмын 4.1-д заасан бүтээгдэхүүнд холбогдох ирээдүйд гарч болзошгүй орлого, зардлыг Хамгийн сайн тооцооллын таамаглалыг ашиглан, 75%-иас доошгүй итгэлийн түвшинтэй сөрөг хазайлтын эрсдэлийн маржингийн хамт тооцоолох ба “хувь тэнцүүлсэн арга”-аар тооцсон даатгалын зуучлагч, төлөөлөгчийн орлогын шимтгэлийн хойшлогдсон зардлыг нэмж, УБХНС-ийн нийт дүнг тодорхойлно.

4.3. Энэ журмын 4.2-т заасан орлогод дараах орлогууд хамаарна. Үүнд:

4.3.1. нийт хураамжийн орлого болон эмнэлгийн, мэргэжлээс шалтгаалах зэрэг бусад нэмэлт эрсдэлд хамаарах нэмэлт хураамжийн орлого;

4.3.2. гэрээнд тусгагдсан нөхцөл бүрдсэн тохиолдолд даатгагчаас даатгуулагчид олгохоор амласан ирээдүйн өгөөж/бенефит/-д хамаарах хураамжийн орлого;

4.3.3. даатгуулагч даатгалын компанийн ашгаас ноогдол ашиг авах эсхүл тусгай өгөөж хүртэх сонголт бүхий хувь оролцоотой гэрээний холбогдох өгөөж/бенефит/-д хамаарах хураамжийн орлого;

4.3.4. даатгалын гэрээнд шууд хамаарах бусад орлого.

4.4. Энэ журмын 4.2-т заасан зардалд дараах зардлууд хамаарна. Үүнд:

4.4.1. Даатгалын үндсэн нөхөн төлбөр, өгөөж;

4.4.2. энэ журмын 4.3.2-т заасан өгөөж/бенефит/;

4.4.3. энэ журмын 4.3.3-т заасан өгөөж/бенефит/;

4.4.4. даатгалын гэрээний зардал (даатгалын зуучлагч, төлөөлөгчийн орлогын шимтгэл зэрэг);

4.4.5. маркетинг борлуулалтын зардал;

4.4.6. даатгалын гэрээ байгуулахтай холбоотойгоор үүссэн төлбөр;

4.4.7. даатгалын гэрээ үргэлжлүүлэхтэй холбогдох төлбөр;

4.4.8.орлогын албан татвараас бусад татварын зардал.

4.5.Энэ журмын 4.2-т заасан орлого, зардалд дараах зүйлс хамаарахгүй. Үүнд:

4.5.1.хөрөнгө оруулалтын өгөөж;

4.5.2.давхар даатгалд даатгуулах болон давхар даатгалын хамгаалалтаас гарахтай холбогдох орлого, зардал;

4.5.3.нэхэмжлэлийн нөөц санд холбогдох энэ журмын 4.3, 4.4-т зааснаас бусад орлого, зарлага.

4.6.Хамгийн сайн тооцооллын таамаглал нь энэ журмын 2.1, 2.3-т зааснаас гадна дараах ерөнхий шаардлагыг хангасан байна. Үүнд:

4.6.1.үндэслэл бүхий үнэлгээ, дүгнэлт хийгдсэн байх;

4.6.2.холбогдох статистик өгөгдөл болон бусад мэдээллийг харгалзан үзсэн байх;

4.6.3.дутуу эсхүл хэтрүүлэн үнэлээгүй байх.

4.7.Энэ журмын 4.2-т заасан УБХНС-г тооцоолох таамаглал нь дараах нөхцөлүүдийг хангасан байна. Үүнд:

4.7.1.Хямдруулалтын хүүгийн түвшин (Discount rate)-ийн таамаглал, тооцоолол нь дараах байдлаар тооцсон эрсдэлгүй хүүгийн түвшин, инфляци, эрсдэлийн хураамжийг үндэслэсэн байна. Үүнд:

4.7.1.1.Эрсдэлгүй хүүгийн түвшинг Монгол Улсын Засгийн газраас гаргасан өрийн хэрэгслийн хамгийн сүүлийн үеийн (сүүлийн 1 жил, шаардлагатай тохиолдолд 1-3 жил) байдлаарх дундаж хүүгийн түвшинтэй ижлээр тооцно;

4.7.1.2.Инфляцийг Монголбанкнаас тухайн жилд зарласан зорилтот түвшинтэй ижлээр тооцно;

4.7.1.3.Эрсдэлийн хураамжийг даатгалын актуарч тооцоолно.

4.7.2.Хүчин төгөлдөр даатгалын гэрээ буюу тэдгээрийн даатгуулагчдын тоо хэмжээ, даатгалын хураамжийн бүрдүүлэлт, нэхэмжлэл, хураамжийн хэмжээ, даатгалын үнэлгээ зэрэг үзүүлэлттэй холбогдох тогтмол зардал болон хувьсах зардлын аль алиныг нь багтаасан зардлын таамаглал, түвшинг тооцоолохын тулд даатгагчийн хамгийн сүүлийн үеийн туршлага/өгөгдлийг ашигласан байна.

4.7.3.Нас баралт, насжилт, өвчлөл, даатгалын тохиолдлын түвшинг багтаасан нэхэмжлэлийн түвшний таамаглалыг тогтоохын тулд хамгийн сүүлийн үеийн даатгагчийн өөрийн болон хүн амын, даатгалын салбарын мэдээллийг харуулсан хүснэгтийг ашигласан байна.

4.7.3.1.Даатгалын багц дүрмийн тавдугаар хавсралтаар баталсан “Даатгалын хэмжээ, даатгалын хураамжийн хэмжээг тооцох аргачлал”-д заасны дагуу тогтоосон насжилтын хүснэгтийг ашиглах ба наслалтын тохируулгыг тооцно. Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн амьдрах хугацаа нь өөр өөр байдагт үндэслэн даатгалын гэрээнд эмэгтэй хүний төлөх даатгалын хураамж нь даатгалын ижил нөхцөлтэй гэрээтэй 3-5 насаар залуу эрэгтэй хүний төлөх хураамжтай адилаар тооцогдоно.

4.7.4.Гэрээ цуцлалтын түвшинг нь даатгагчийн хамгийн сүүлийн үеийн даатгагч, даатгуулагчийн аль нэгний саналын дагуу даатгалын гэрээ дуусахаас өмнө цуцлах хэмжээг харгалзан тооцно.

4.8.Ижил бүтээгдэхүүний бүлэг дэх даатгалын гэрээний УБХНС-ийн нийт дүн тэгээс доош байж болохгүй.

4.9.Даатгалын гэрээг хүчингүй болгох/гэрээний хугацаа дуусах үед бүрдүүлсэн нийт УБХНС-н дүн нийт мөнгөн дүн буюу буцаан олгохоор амласан хураамжийн буцаалтаас бага байвал даатгагч нь УБХНС-ийн хэмжээг доод тал нь мөнгөн дүн буюу уг хураамжийн буцаалтын хэмжээнд хүртэл нэмэгдүүлнэ.

4.10. Бүтээгдэхүүний 1, 4-р бүлгийн хувьд УБХНС-г дараах аргачлалаар бүрдүүлж, хуваарилна:

4.10.1. УБХНС-г даатгагчийн хүчин төгөлдөр даатгалын гэрээнүүдийн хувьд өмнөх тайлант хугацааны эцэс дэх учирч болох хохирол болон үйл ажиллагааны зардлын нийлбэр нь орлогод тооцоогүй хураамжийн нөөцөөс давсан тохиолдолд тухайн нэмэгдэл хариуцлагын хэмжээгээр тооцно.

4.10.2. УБХНС-г 1, 4-р бүлгийн бүтээгдэхүүнд хамаарах даатгалын хэлбэр тус бүрийн хувьд дараах томъёо ашиглан байгуулна. Хаалтнаас гарах үр дүн сөрөг байвал энэхүү нөөцийг нэмэгдүүлэхгүй:

$$УБХНС_i = \left(\frac{НТ_i + УАЗ_i}{ЦХ_i - \Delta ОТХН_i} - 1.00 \right) * ОТХН_i$$

. Үүнд:

НТ_i – 1, 4-р бүлгийн бүтээгдэхүүний хамаарах *i* дугаар даатгалын хэлбэрийн даатгалын нөхөн төлбөрийн цэвэр зардал/давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр орохгүй/ ба нэхэмжлэлийн нөөц сангийн өөрчлөлтийн нийлбэр/давхар даатгагчид ногдох хэсэг орохгүй/,

УАЗ_i – 1, 4-р бүлгийн бүтээгдэхүүний хамаарах *i* дугаар даатгалын хэлбэрийн үйл ажиллагааны зардал,

ЦХ_i – 1, 4-р бүлгийн бүтээгдэхүүний хамаарах *i* дугаар даатгалын хэлбэрийн даатгалын хураамжийн цэвэр орлого;

ΔОТХН_i – 1, 4-р бүлгийн бүтээгдэхүүний хамаарах *i* дугаар даатгалын хэлбэрийн даатгалын орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн нийт өөрчлөлт /хойшлуулсан давхар даатгалын хураамжийн өөрчлөлтийг хасна/,

ОТХН_i – 1, 4-р бүлгийн бүтээгдэхүүний хамаарах *i* дугаар даатгалын хэлбэрийн даатгалын Орлогод тооцоогүй хураамжийн нөөц /хойшлуулсан давхар даатгалын хураамжийн дүнг хасна/.

4.10.2.1. энэ журмын 4.3.2-д заасан үйл ажиллагааны зардалд даатгалын гэрээний зардал, ерөнхий ба удирдлагын зардал, борлуулалт маркетингийн зардал, санхүүгийн зардал болон бусад зардал хамаарна. Эдгээр зардлуудыг Бүтээгдэхүүний бүлэг, хэлбэрээр задлах боломжгүй бол Бүтээгдэхүүний бүлэгт хамаарах хэлбэр тус бүрийн орлогод тооцсон хураамжийг нийт орлогод тооцсон хураамжид харьцуулсан хувийн жинг үйл ажиллагааны зардлын дүнгээр үржүүлэн Бүтээгдэхүүний бүлэгт хамаарах даатгалын хэлбэр тус бүрээрх зардлын задаргааг тооцож болно.

4.10.3. УБХНС-ийн нийт хэмжээ нь даатгалын бүтээгдэхүүний бүлэгт хамаарах даатгалын хэлбэр тус бүрээр байгуулсан учирч болзошгүй хохирлын нөөц сангуудийн нийлбэртэй тэнцүү бөгөөд дараах томъёогоор тооцно:

$$УБХНС_t = \sum_{i=1}^n УБХНС_i$$

. Үүнд:

УБХНС_t - учирч болзошгүй хохирлын нөөц сангийн нийт дүн.

4.10.4. Даатгагч энэ журмын 4.10.2-т заасан томъёоны хувьсагчдын ирээдүйн төсөөллийг тооцох статистик суурь мэдээлэл хангалттай бөгөөд тооцох боломжтой гэж үзвэл тэдгээрийг томъёоны харгалзах хэсгүүдэд орлуулан тооцоолж болно.

Тав. Хөрөнгө оруулалттай холбоотой бүтээгдэхүүний нөөц санг тооцоолох

5.1.Хөрөнгө оруулалттай холбоотой бүтээгдэхүүний нийт хураамж нь хөрөнгө оруулалтын болон даатгалын хамгаалалтын хураамжаас бүрдэнэ.

5.2.Даатгагч нь даатгалын гэрээ бүрийн нийт хураамжийн хөрөнгө оруулалтад байршуулах хэсэг буюу хөрөнгө оруулалтын хураамж, түүнийг хөрөнгө оруулалтад байршуулсны орлого зэрэг нийт орлого болон хөрөнгө оруулалттай холбогдох аливаа зардлаас бүрдсэн хуримтлалын сан (цаашид “даатгуулагчийн хөрөнгө оруулалтын сан” гэх)-г байгуулах ба энэ нь хуримтлагдсан хөрөнгийн тайлагналын өдрийн байдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдэнэ.

5.3.Баталгаат өгөөж амласан хөрөнгө оруулалттай холбоотой бүтээгдэхүүний хувьд энэ журмын 5.2-т заасан сангаас гадна хөрөнгө оруулалтын хураамжийн нөөц санг бүрдүүлэх ба дараах байдлаар тооцоолно. Үүнд:

5.3.1.тайлагналын өдрийн байдлаарх гэрээний дагуу олгогдох хөрөнгө оруулалтад холбогдох нөхөн төлбөрийн өнөөгийн үнэ цэнээс энэ журмын 5.2-д заасан хуримтлагдсан хөрөнгийн бодит үнэ цэнийг хассан ялгаврын эерэг утгатай тэнцүү байна.

5.3.2.тооцоололд ашиглагдах хямдруулалтын хүү, зардлын түвшин нь энэ журмын 4.7.1, 4.7.2-т заасан шаардлагуудыг хангасан байна.

5.4.Даатгалын хамгаалалтын хураамжийн хувьд даатгалын гэрээ, түүний эрсдэлийн шинж чанараас хамааран дараах нөөц сангуудыг байгуулна. Үүнд:

5.4.1.энэ журмын нэгдүгээр хавсралтад заасан Бүтээгдэхүүний 4-р бүлгийн хувьд энэ журмын гуравдугаар бүлэгт заасны дагуу ОТНХ, энэ журмын 4.10-т заасны дагуу УБХНС.

5.4.2.Бүтээгдэхүүний 5-р бүлгийн хувьд энэ журмын 4.2-т заасны дагуу УБХНС.

Зургаа. Нэхэмжлэлийн нөөц сан

6.1.Даатгагчийн нэхэмжлэлийн нөөц сан нь Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан (цаашид МБТХНС гэх) болон Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан (цаашид УБМХНС гэх)-ийн нийлбэртэй тэнцүү байна.

6.2.Даатгагч тайлагналын өдөр шийдвэрлэгдээгүй үлдсэн болон тайлагналын өдрөөс өмнөх хугацаанд үүссэн бөгөөд даатгагчид мэдэгдэхээр хүлээгдэж байгаа бүх нэхэмжлэлийг барагдуулахтай холбоотой нийт хариуцлагыг тооцсон байна.

6.3.Энэ журмын 6.2-т заасан бүх нэхэмжлэлийг барагдуулах зардалд даатгуулагчид төлөхөөр тооцоолсон нөхөн төлбөрөөс гадна нөхөн төлбөрийн үнэлгээний зардал мөн хамаарна.

6.4.МБТХНС-г дараах аргачлалаар бүрдүүлж, хуваарилна. Үүнд:

6.4.1.МБТХНС-д тайлангийн хугацаанд даатгуулагч эсхүл даатгалын гэрээнд заагдсан холбогдох бусад этгээдээс даатгагчид тухайн гэрээнд заасан аливаа хэлбэрээр /бичгээр, утсаар, емэйлээр болон бусад/ мэдэгдсэн даатгалын тохиолдлоос үүсэх даатгагчийн урьдчилан тооцоолсон хариуцлагын хэмжээ болон тайлангийн хугацаанд төлөгдөөгүй үлдсэн нэхэмжлэлийн хэмжээ хамаарна.

6.4.2.МБТХНС-ийн нийт хэмжээг дараах томъёогоор тооцно:

$$\text{МБТХНС} = (A + B - B + \Gamma) . \text{ Үүнд:}$$

МБТХНС - даатгалын гэрээ тус бүрээр тооцсон МБТХНС;

A – тайлангийн үеэс /сар, улирал, жил байж болох/ өмнөх үед даатгалын тохиолдол нь учирсан бөгөөд нэхэмжилсэн эсэхээс үл хамааран даатгагчид мэдэгдсэн даатгалын хохирлын/өр төлбөрийн дүн /өмнөх тайлант үеийн МБТХНС-ийн тухайн гэрээгээрх үлдэгдэл

буюу тухайн хугацаанд хамаарах даатгалын нэхэмжлэлийн дүн дээр даатгагчид мэдэгдсэн боловч нэхэмжлээгүй хохирлыг/өр төлбөрийг нэмсэн дүнтэй тэнцэнэ/;

Б – тайлангийн үед даатгалын тохиолдол нь учирсан бөгөөд нэхэмжилсэн эсэхээс үл хамааран даатгагч мэдсэн даатгалын хохирлын/өр төлбөрийн дүн /даатгалын нэхэмжлэлийн дүн дээр даатгагчид мэдэгдсэн боловч нэхэмжлээгүй хохирлыг/өр төлбөрийг нэмсэн дүнтэй тэнцэнэ/.

В – тайлангийн хугацаанд /зөвхөн тухайн улиралд/ барагдуулсан нэхэмжлэл;

Г – тайлангийн хугацааны эцэст шийдвэрлэгдээгүй байгаа хохирлыг/нэхэмжлэлийг үнэлэх/баталгаажуулах зардал, жишээ нь хохирол үнэлгээний зардал, хөндлөнгийн шинжээчийн зардал гэх мэт.

6.4.3.Энэ журмын 6.4.2-т заасан мэдэгдсэн боловч нэхэмжлээгүй хохирлын/өр төлбөрийн дүнг тооцоход хүндрэлтэй тохиолдолд тооцоолол хийж буй өдрөөс өмнөх 2-оос дээш жилд ижил төстэй бүтээгдэхүүний бүлэг, даатгалын бүтээгдэхүүн, эрсдэл, гэрээний хувьд төлсөн нөхөн төлбөр (үүнд нөхөн төлбөрийн үнэлгээний зардал багтсан байна) ба даатгалын үнэлгээний харьцааны арифметик дундаж дүнг тооцоолол хийх гэж буй гэрээний даатгалын үнэлгээний дүнгээр үржүүлэн тооцоолно.

6.4.4.Шүүхийн маргаантай байгаа нэхэмжлэлийн хувьд МБТХНС-г нэхэмжлэгчийн шаардлагын дүнгээр, даатгалын үнэлгээнээс хэтрэхгүйгээр тооцож нөөц байгуулна. Ийнхүү байгуулсан нөөцийг шүүхийн эцсийн шийдвэр гарах хүртэл нөөцөд хэвээр үлдээнэ. Хэрэв даатгагч уг нөөц санг нэмж байгуулах шаардлагатай гэж үзсэн бол МБТХНС-г нэмэгдүүлж болно.

6.4.5.Даатгагч анхан шатны мэдээлэл дээр үндэслэн МБТХНС-г байгуулсан бөгөөд нэмэлт мэдээлэл болон хөндлөнгийн байгууллагын шинжилгээг үндэслэн нөхөн төлбөрийн дүнг эцэслэн гарахад өмнөх байгуулсан нөөц сангийн дүнгээс их эсвэл бага байвал МБТХНС-г нэмэгдүүлж эсхүл бууруулж болно.

6.4.6.Аннуити даатгалын гэрээний хувьд МБТХНС-ийн дүн 0-тэй тэнцүү байна.

6.5.УБМХНС-г дараах аргачлалаар бүрдүүлж, зарцуулна. Үүнд:

6.5.1.УБМХНС-г даатгагч Бүтээгдэхүүний бүлэг, түүний хамаарах даатгалын хэлбэр тус бүрээр үнэн зөв бөгөөд бодитой статистикт тулгуурлан Хамгийн сайн тооцооллын таамаглалд үндэслэн тооцно. Тухайн нөөцийг тайлант хугацааны эцсийн байдлаар учирсан боловч мэдэгдээгүй байгаа хохирол/өр төлбөрт зориулан байгуулна.

6.5.2.УБМХНС-г тооцоход даатгагч хохирлын гурвалжны хөгжлийн аргуудыг ашиглах ба дараах шаардлагуудыг хангасан байна:

6.5.2.1.Хохирол/өр төлбөрийн үнэлгээний зардлыг учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нийт дүнд оруулан тооцно.

6.5.2.2.Жигд бус тархалттай, их хэмжээний хохиролд актуарч актуар тооцооллын шаардлагаар тохируулга хийх, шаардлагатай тохиолдолд өөр бусад актуар аргачлал, таамаглалыг ашиглаж болох бөгөөд Даатгалын нөөц сангийн актуар тайланд энэ талаар тусгасан байна.

6.5.3.Тайлагналын өдрөөр даатгалын хариуцлага гэрээний дагуу дууссан, шинээр даатгалын хариуцлага нэмэгдсэн эсвэл даатгалын тохиолдол болсныг даатгуулагч мэдэгдсэн зэрэг нөлөөг актуар тооцооллоор тооцсоноор УБМХНС-г өмнөх тайлант хугацааны дүнгээс нэмэгдүүлэх эсвэл бууруулна.

6.5.4.Аннуити, тэтгэврийн болон хуримтлалын даатгалын хувьд УБМХНС-ийн дүн 0-тэй тэнцүү байна.

Долоо. Нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсэг

7.1. Даатгагч нь энэ журмын гурав, дөрөв, тав, зургаадугаар бүлэгт тусгагдсан ОТХН, нөөц сангуудын давхар даатгагчид ногдох хэсгийг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

7.1.1. Даатгалын ОТХН, нөөц сан дахь давхар даатгагчид ногдох хэсгийг даатгагч энэ журамд заасан харгалзах нөөц, нөөц сантай адил аргачлалаар эсхүл давхар даатгалын гэрээний хэлбэр /хувь тэнцүүлсэн, хувь тэнцүүлээгүй, сайн дурын, албан журмын гэх мэт/, нөхцөлөөс хамааруулан өөрөөр тооцож болно.

7.1.2. Хойшлогдсон давхар даатгалын хураамж буюу давхар даатгагчид ногдох ОТХН-ийн тооцооллыг энэ журмаар заасан ОТХН тооцох аргачлалтай нэгэн адил аргачлалаар эсхүл хэрэв давхар даатгалын гэрээнд заасан бол тухайн нөхцөлөөр тус тус тооцоолно.

7.1.3. Даатгалын нөөцийн давхар даатгагчид ногдох УБМХНС-ийн хэсэг буюу давхар даатгагчид ногдох учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөцийг давхар даатгуулсан даатгалын зүйлд учирсан даатгалын тохиолдолд хамаарах даатгалын гэрээ бүрийн хувьд байгуулна. Энэ нь давхар даатгалын гэрээнд заагдсан, давхар даатгагчаас олгох боломж бүхий мөнгөн дүнтэй тэнцүү байна.

7.1.4. Давхар даатгагчид ногдох учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөцийг бүтээгдэхүүний бүлэг, түүний хамаарах даатгалын хэлбэр тус бүрээр давхар даатгалд шилжүүлсэн нөхөн төлбөрийн статистик мэдээлэлд тулгуурлан бүтээгдэхүүний бүлэг, түүний хамаарах хэлбэр тус бүрийн хувьд дараах томъёогоор тооцно:

$$ДД_i = УБМХНС_t * \frac{НТ_{re}}{НТ_t}$$

. Үүнд:

ДД_i – даатгалын “i” хэлбэрээр УБМХНС-ийн давхар даатгагчид ногдох хэсгийн дүн;
УБМХНС_t – даатгалын “i” хэлбэрээр байгуулсан нийт УБМХНС-ийн хэмжээ;
НТ_{re} – даатгалын “i” хэлбэрийн хувьд давхар даатгалаас төлөгдсөн нөхөн төлбөр;
НТ_t – даатгалын “i” хэлбэрийн хувьд тайлангийн хугацаанд төлөгдсөн нийт нөхөн төлбөрийн хэмжээ.

7.1.5. Бүх хэлбэрээрх давхар даатгагчид ногдох УБМХНС-уудын нийлбэрээр давхар даатгагчид ногдох УБМХНС-г тооцно.

$$ДД_t = \sum_{i=1}^n ДД_i$$

. Үүнд:

ДД_t = Бүх хэлбэрээрх давхар даатгагчид ногдох УБМХНС-ийн хэмжээ.

7.2. Даатгагч нь давхар даатгагчид ногдох нөөц сангийн хэсгийг тооцохдоо даатгагчийн давхар даатгалын нэхэмжлэлийг барагдуулах чадавхи, давхар даатгагчаас буцаан төлүүлэх боломж зэргийг харгалзан үзнэ. Актуарч эдгээр үйл ажиллагаанд эрсдэл байгаа эсэхийг судалж, тооцох бөгөөд даатгалын нөөц сан байгуулахад давхар даатгалын эрсдэлийг хэрхэн тооцсон талаар Даатгалын нөөц сангийн актуар тайланд тодруулан тусгасан байна.

7.3. Даатгагч, давхар даатгагч, дахин буюу ретро давхар даатгагчдын хооронд хийгдэж буй хөрөнгийн аливаа гүйлгээ нь бодитой, нотлогдсон байна.

Найм. Алдагдлаас хамгаалах сан

8.1. Давхар даатгагч даатгалын хохирлыг нөхөн төлөх нөөц сан хүрэлцэхгүй болсон тохиолдолд ашиглах зориулалт бүхий алдагдлаас хамгаалах санг мөнгөн хөрөнгөөр бүрдүүлэх бөгөөд

түүний доод хэмжээ нь 15 тэрбум төгрөг байна. Алдагдлаас хамгаалах санг зээлийн хөрөнгөөр бүрдүүлж болохгүй.

8.2. Давхар даатгагч Хорооноос тогтоосон алдагдлаас хамгаалах сангийн доод хэмжээний 1/3 хэсгийг эхний давхар даатгалын гэрээ байгуулахаас өмнө, дараагийн 1/3 хэсгийг Хорооноос тусгай зөвшөөрөл авснаас хойш 1 жилийн дотор, үлдсэн 1/3 хэсгийг 3 жилийн дотор тус тус бүрдүүлнэ.

8.3. Давхар даатгуулагчаас даатгалын гэрээний дагуу нэхэмжилсэн даатгалын нөхөн төлбөрийг давхар даатгагчийн хохирол төлөх нөөц сангаас төлж хүрэлцэхгүй болсон тохиолдолд зөрүүг алдагдлаас хамгаалах сангаас олгоно.

8.4. Алдагдлаас хамгаалах санг Даатгалын багц дүрмийн дөрөвдүгээр хавсралт “Даатгалын нөөц санд болон албан журмын даатгалын санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ, түүнийг хөрөнгө оруулалтад байршуулахад тавигдах нөхцөл, шаардлага”-д заасан болон энэ журмын 8.3-д зааснаас өөрөөр зарцуулж болохгүй.

8.5. Алдагдлаас хамгаалах сангаас нөхөн төлбөрийг олгосон тохиолдолд нөхөн төлсөн төлбөрийн дүнтэй уялдуулан алдагдлаас хамгаалах сангийн хөрөнгийн дахин бүрдүүлэлтийг дараах байдлаар хийнэ:

8.5.1. Алдагдлаас хамгаалах сангаас олгосон нөхөн төлбөрийн дүн уг сангийн 1/3 хэсэг хүртэл бол уг хөрөнгийг 1 жилийн дотор;

8.5.2. Алдагдлаас хамгаалах сангаас олгосон нөхөн төлбөрийн дүн уг сангийн 1/3-2/3 хүртэл бол 2 жилийн дотор, үүнээс 1/3 хэсгийг эхний нэг жилийн дотор, үлдэх хэсгийг дараагийн нэг жилийн дотор;

8.5.3. Алдагдлаас хамгаалах сангаас олгосон нөхөн төлбөрийн дүн уг сангийн 2/3 хэсгээс дээш бол 2 жилийн дотор, үүнээс эхний 1/3 хэсгийг 1 сарын дотор, үлдэх хэсгийг энэ журмын 8.5.2-т заасны дагуу тус тус дахин бүрдүүлнэ.

8.6. Алдагдлаас хамгаалах сангаас нөхөн төлбөр олгох болсон тохиолдолд Хороонд 7 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

Ес. Хяналт, хариуцлага

9.1. Даатгагч даатгалын нөөц санг тооцоолох аргачлал, таамаглалд өөрчлөлт оруулах тохиолдолд дараах хяналт, хариуцлагын арга хэмжээг дагаж мөрдөнө. Үүнд:

9.1.1. даатгагч өөрчлөлт оруулах аргачлал, таамаглалыг ашиглахаас 30-аас доошгүй хоногийн өмнө өөрчлөлтийн шалтгаан болон нөөц сангийн хэмжээ, даатгагчийн төлбөрийн чадварын түвшинд үзүүлэх нөлөөлөл, аргачлал болон таамаглал дахь өөрчлөлт нь энэ журамд заасан холбогдох шаардлагуудыг хэрхэн хангаж буй талаар үндэслэлтэй дүгнэлт, тайлбар бүхий даатгагчийн томилсон актуарчийн санал, даатгагчийн хүсэлтийг Хороонд хүргүүлж, мэдэгдэнэ;

9.1.2. Хороо хүсэлт, санал, тайлбарыг ажлын 15 хоногийн дотор хянаж, шаардлагатай гэж үзвэл аргачлал, таамаглалд өөрчлөлт оруулахыг шаардаж болно;

9.1.3. Хороо хариу мэдэгдэхээс өмнө таамаглал, аргачлалыг өөрчилж болохгүй.

9.2. Даатгагч энэ журмын 2.5-д заасан Дотоод журамтай холбогдох дараах хяналт, хариуцлагын арга хэмжээг дагаж мөрдөнө. Үүнд:

9.2.1. Дотоод журмыг шинээр батлах, шинэчлэх, аливаа нэмэлт өөрчлөлт оруулах төслийг актуарч хянаж, даатгагчийн гүйцэтгэх удирдлага баталгаажуулна;

9.2.2. Дотоод журам, түүнд оруулсан аливаа өөрчлөлтийн төслийг баталснаас хойш 10 хоногт, хүчин төгөлдөр болохоос 10-аас багагүй хоногийн өмнө Хороонд хүргүүлнэ;

9.2.3.Хороо шаардлагатай гэж үзвэл Дотоод журамд өөрчлөлт оруулахыг шаардаж болно.

9.3.Даатгагч энэ журмын 2.6.1-т заасан тусгай нөөц сантай холбогдох дараах хяналт, хариуцлагын арга хэмжээг дагаж мөрдөнө. Үүнд:

9.3.1.тусгай нөөц сангаас зарцуулалт хийхээр бол Хороонд хүсэлтээ бичгээр тавих ба хүсэлтэд тусгай нөөц санг зарцуулах үндэслэл, хэмжээ, тооцоолол, тайлбарыг тодорхой тусгасан байна;

9.3.2.Хороо даатгагчаас ирүүлсэн хүсэлтийг хянаж, шаардлагатай гэж үзвэл өөрчлөлт оруулахыг шаардаж болно;

9.3.3.Хороо хариу мэдэгдэхээс өмнө даатгагч тус нөөц сангаас зарцуулалт хийж болохгүй.

9.4.Даатгагч татан буугдсан, дампуурсан тохиолдолд даатгалын бүх нөхөн төлбөр, хураамжийн буцаалт хийгдсэний дараах нөөц сангийн үлдэгдлээс Хорооноос томилсон актуарчийн актуар тооцооллын дагуу тохирох хэсгийг даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор Даатгагчдын холбооны тусгайлсан дансанд байршуулна.

9.5.Энэ журмын 9.4-д заасан тусгайлсан дансанд нөөц сангийн мөнгөн хөрөнгийг байршуулах болон зарцуулах үйл ажиллагааг холбогдох журмаар зохицуулах бөгөөд хэрэгжилтэд Хороо байнгын хяналт тавина.

9.6.Даатгагч нь жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан даатгалын нөөц сангийн үлдэгдлийг Хорооноос олгосон эрх бүхий актуарч эсхүл олон улсын мэргэжлийн холбоодоос олгосон Associate ба түүнтэй адилтгах түвшний болон түүнээс дээш эрхтэй актуарчаар баталгаажуулсан байна.

9.7.Даатгагч нь энэ журмын дөрөвдүгээр хавсралт “Даатгалын нөөц сангийн актуар тайлангийн загвар” болон Актуарын стандартын дагуу Даатгалын нөөц сангийн актуар тайланг гаргаж, санхүүгийн тайлангийн хамт улирал бүр Хороонд ирүүлнэ.

9.8.Энэ журмын 9.7-д заасан тайланг шаардлагатай тохиолдолд Хороо хэдийд ч шаардаж авч болохоос гадна тайлантай холбогдуулан нэмэлт мэдээлэл, материал шаардаж болно.

9.9.Энэхүү журмын хэрэгжилтэд Хороо хяналт тавих бөгөөд зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Арав. Даатгалын нөөц сангуудын үлдэгдлийн тохируулга, хэрэгжүүлэх арга хэмжээ

10.1.Даатгагч энэхүү журмын дагуу даатгалын нөөц санг бүрдүүлэн, тооцоолохтой холбогдуулан дараах шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

10.1.1.Энэ журмын хоёрдугаар хавсралтад тусгагдсаны дагуу нэр бүхий бүртгэлүүдийг үүсгэх, өөрчлөн шинэчлэх зорилгоор даатгагчийн мэдээллийн технологи, програм хангамжийн бэлэн байдлыг бүрдүүлсэн байх;

10.1.2.Энэ журмын нэгдүгээр хавсралтад заасны дагуу даатгалын бүтээгдэхүүн, гэрээг бүлэглэх ба даатгалын хэлбэр бүрийн хувьд Бүтээгдэхүүний бүлэг тус бүрд хамаарах бүтээгдэхүүний жагсаалтыг гаргасан байх;

10.1.3.Хорооны 2019 оны 02 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан “Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам”-д заасны дагуу тооцолж, тайлагнах 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх нийт даатгалын нөөц сангийн хувьд энэ журамд заасны дагуу бүлэглэсэн Бүтээгдэхүүний бүлэг тус бүрт ногдох нөөц сан, давхар даатгагчид ногдох хэсэг бүрийн хэмжээ, тэдгээрийн эзлэх хувийг даатгалын хэлбэрийн бүрийн хувьд тодорхойлсон байх;

10.1.4.Энэ журамд заасны дагуу даатгалын нөөц санг тооцоолох таамаглал аргачлалыг тодорхойлсон байх;

10.1.5.Энэ журмын 2.5-д заасан Дотоод журмыг энэ журмын гуравдугаар хавсралтад тусгагдсан нөхцөлийн дагуу өөрчлөн шинэчилсэн байх;

10.1.6.Энэ журамд заасан таамаглал аргачлалын дагуу даатгалын нөөц санг тооцоолоход шаардлагатай дор хаяж сүүлийн 3 жилийн дата өгөгдөл, мэдээллийг бэлтгэсэн байх;

10.1.7.Энэ журмын 10.1.4-т заасны дагуу тодорхойлсон таамаглал аргачлалын дагуу даатгалын нөөц сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх нөөц сангийн хэмжээг тодорхойлж, Бүтээгдэхүүний бүлэг тус бүрт ногдох нөөц сан, давхар даатгагчид ногдох хэсэг бүрийн хэмжээ, нийт нөөц санд эзлэх хувийг даатгалын хэлбэр бүрийн хувьд тодорхойлсон байх.

10.2.Даатгагч даатгалын нөөц сан, тэдгээрийн давхар даатгагчид ногдох хэсгийн 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн үлдэгдлийг дараах байдлаар тохируулна. Үүнд:

10.2.1.Ердийн даатгагчийн хувьд:

10.2.1.1.ОТХН-ийн үлдэгдлийг Бүтээгдэхүүний 1-р бүлэгт хамаарах энэ журмын 10.1.3-т заасан хэмжээгээр;

10.2.1.2.УБХНС-ийн үлдэгдлийг Бүтээгдэхүүний 1-р бүлгийн хувьд тус бүлэгт хамаарах энэ журмын 10.1.3-т заасан хэмжээгээр, Бүтээгдэхүүний 2-р бүлгийн хувьд энэ журмын 10.1.3-т заасны дагуу тодорхойлсон тухайн бүлэгт хамаарах ОТХН болон УБХНС-ийн нийлбэрээр;

10.2.1.3.Нэхэмжлэлийн нөөц сангуудын үлдэгдлийг Бүтээгдэхүүний бүлэг тус бүрт хамаарах энэ журмын 10.1.3-т заасан хэмжээгээр;

10.2.1.4.Тусгай нөөц сангийн үлдэгдлийг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдлийн хэмжээгээр;

10.2.2.Урт хугацааны даатгагчийн хувьд энэ журмын 10.1.7-д заасны дагуу тодорхойлсон Бүтээгдэхүүний бүлэг тус бүрийн нийт нөөц санд эзлэх хувь болон энэ журмын 10.1.3-т заасан 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх нийт нөөц сангийн хэмжээний үржвэрийн дүнгээр;

10.2.3.Давхар даатгагчийн хувьд:

10.2.3.1.ердийн даатгалын бүтээгдэхүүнд холбогдох даатгалын нөөц санг энэ журмын 10.2.1.1-10.2.1.3 заасантай адил аргачлалаар;

10.2.3.2.урт хугацааны даатгалын бүтээгдэхүүнд холбогдох даатгалын нөөц санг энэ журмын 10.2.2-т заасантай адил аргачлалаар;

10.2.3.3.Алдагдлаас хамгаалах сангийн үлдэгдлийг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдлийн хэмжээгээр.

“Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам”-ын нэгдүгээр хавсралт

ДААТГАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БҮЛЭГ

Бүтээгдэхүүний			Бүрдүүлэх нөөц сан				
ангилал	бүлгийн дугаар	шинж чанар	ОТХН	УБХНС	Нэхэмжлэлийн нөөц сан	Хөрөнгө оруулалтын хураамжийн нөөц сан	Даатгуулагчийн хөрөнгө оруулалтын сан
Хөрөнгө оруулалттай холбогдохоос бусад	1	Нэг жил хүртэлх хугацаатай болон нэг жилээс дээш хугацаатай боловч жил бүр гэрээний нөхцөлийг шинэчлэх боломжтой бүтээгдэхүүн. Жишээ нь: Нэг жил хүртэлх хугацаатай урт хугацааны/амьдралын даатгал, эрүүл мэндийн даатгал, ердийн даатгалын бүтээгдэхүүн зэрэг.	+	+	+		
	2	Нэг жилээс дээш хугацаатай, даатгалын гэрээний хугацаанд гэрээний нөхцөлийг шинэчлэх боломжгүй бүтээгдэхүүн. Жишээ нь: а.Хугацаат амьдралын даатгал, ипотекийн зээлдэгчийн амь насны даатгал, насан туршийн даатгал, аннуити даатгал; б.даатгалын хугацаа дууссаны дараа тодорхой хураамжийн буцаалт олгох урт хугацааны/амьдралын даатгалын бүтээгдэхүүн; в.Нэг жилээс дээш хугацаатай, даатгалын хураамжийг нэг удаа эсхүл тодорхой хугацаанд нэгтгэсэн дүнгээр төлж, даатгалын нөхцөлийг хянан үзэж, өөрчлөх боломжгүй ердийн даатгалын бүтээгдэхүүн.		+	+		
	3	Нэг жилээс дээш хугацаатай, даатгалын гэрээний нөхцөл нь шинэчлэгддэг ба тодорхой хугацааны дараа нэмэлт өгөөж хүртэх боломжтой бүтээгдэхүүн. Жишээ нь: а.даатгалын хамгаалалтаас гадна тодорхой хүүтэй хураамжийн хуримтлалыг амласан нэмэлт өгөөж/бенефит/ бүхий бүтээгдэхүүн;		+	+		

		б.тодорхой хугацаанд нэхэмжлэл гаргаагүй тохиолдолд нэмэлт өгөөж /бенефит/, урамшуулал амласан бүтээгдэхүүн.					
Хөрөнгө оруулалттай холбогдох*	4	Даатгалын гэрээний нөхцөл нь гэрээний жилийн ой бүрээр шинэчлэгдэх боломжтой бөгөөд тодорхой хугацааны дараа даатгалын хамгаалалтыг нэмэгдүүлэхээр амлаагүй бүтээгдэхүүн	+	+	+	+	+
	5	Даатгалын гэрээний жилийн ой болгоноор даатгалын гэрээний нөхцөл нь шинэчлэгдэх боломжгүй ба/эсвэл тодорхой хугацааны дараа даатгалын хамгаалалтыг нэмэгдүүлэхээр амласан бүтээгдэхүүнүүд		+	+	+	+

*Даатгалын багц дүрмийн нэгдүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 7.1.12-т заасан Хөрөнгө оруулалттай холбогдох бүтээгдэхүүн.

“Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам”-ын хоёрдугаар хавсралт

Даатгагчийн бүртгэлийн агуулга

1. Даатгуулагчтай байгуулсан даатгалын гэрээний бүртгэлд дор хаяж дараах мэдээллийг тусгана. Үүнд:

- 1.1. даатгалын гэрээний (даатгалын баталгааны) дугаар;
- 1.2. даатгуулагч нь хувь хүн тохиолдолд:
 - а. даатгуулагчийн овог, нэр, регистрийн дугаар;
 - б. даатгуулагчийн нас, хүйс, даатгалын хураамжид нөлөөлж болох бусад үзүүлэлт;
- 1.3. даатгуулагч нь хуулийн этгээд тохиолдолд:
 - а. оноосон нэр, хуулийн этгээдийн хэлбэр, төрөл, регистрийн дугаар;
 - б. үндсэн үйл ажиллагаа чиглэл, салбар, даатгалын хураамжид нөлөөлж болох бусад үзүүлэлт;
- 1.4. бүлгийн даатгал тохиолдолд даатгалд хамрагдсан этгээдүүдийн 1.2, 1.3-д заасан мэдээлэл;
- 1.5. даатгуулагчаас бусад даатгалын нөхөн төлбөр авах эрхтэй этгээдийн 1.2, 1.3-д заасан мэдээлэл;
- 1.6. гэрээ байгуулсан огноо, даатгалын хамгаалалт эхэлсэн ба дуусах огноо;
- 1.7. даатгалын хугацаа болон даатгалын гэрээний нөхцөл гэрээний жилийн ой бүрээр шинэчлэгдэх боломжтой эсэх, хөрөнгө оруулалттай холбоотой гэрээ эсэх /урт хугацааны даатгагчийн хувьд/ талаарх мэдээлэл
- 1.8. даатгалын гэрээний нөхцөл өөрчлөгдсөн огноо;
- 1.9. даатгалын үндсэн болон нэмэлт эрсдэлүүд;
- 1.10. хөрөнгө оруулалттай холбоотой бүтээгдэхүүний хувьд хөрөнгө оруулалтын багц дахь хөрөнгө оруулалтын хэрэгсэл, тэдгээрийн эзлэх хувь хэмжээ;
- 1.11. даатгалын зүйл;
- 1.12. даатгалын үнэлгээ;
- 1.13. даатгалын нийт хураамж;
- 1.14. хүлээж авсан даатгалын хураамжийн хэмжээ, огноо, хуваарь;
- 1.15. даатгалын гэрээг зуучлан борлуулсан бол зуучлагч, төлөөлөгчийн нэр болон шимтгэлийн хувь, хэмжээ;
- 1.16. даатгалын гэрээний зардал, түүний хувь, хэмжээ;
- 1.17. даатгалын гэрээ цуцалснаар буцаан төлсөн даатгалын хураамж, огноо;

2. Даатгалын тохиолдол, нэхэмжлэлийн бүртгэлд дор хаяж дараах мэдээллийг тусгана. Үүнд:

- 2.1. даатгалын гэрээний дугаар;
- 2.2. даатгалын тохиолдлын талаарх мэдээллийг хүлээн авсан хэлбэр /даатгагчтай утсаар, шуурхай албаны утсаар, цахим шуудангаар, бичгээр гэх мэт/;
- 2.3. даатгалын тохиолдлын огноо, даатгалын эрсдэл;
- 2.4. энэ журмын 6.4.2-д заасан мэдэгдсэн боловч нэхэмжлээгүй хохирлын/өр төлбөрийн дүн;
- 2.5. нөхөн төлбөрийн нэхэмжлэлийн өргөдлийн огноо, нэхэмжилсэн хэмжээ;

- 2.6.шүүхийн маргаантай холбогдсон нэхэмжлэл эсэх, тийм бол шүүхэд нэхэмжлэл гаргасан тал, огноо, шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн эсэх зэрэг холбогдох мэдээдэл
 - 2.7.мэдэгдсэн нэхэмжлэлийн өөрчлөлтийн хэмжээ, өөрчлөлтийн шалтгаан, огноо;
- 3.Даатгалын нөхөн төлбөрийн бүртгэлд дор хаяж дараах мэдээллийг тусгана. Үүнд:
- 3.1.Даатгалын гэрээний дугаар;
 - 3.2.Даатгалын тохиолдлын огноо, энэ журмын 6.4.2-д заасан мэдэгдсэн боловч нэхэмжлээгүй хохирлын/өр төлбөрийн дүн;
 - 3.3.нөхөн төлбөрийн нэхэмжлэлийн огноо, хэмжээ;
 - 3.4.нөхөн төлбөр олгосон огноо, хэмжээ;
 - 3.5.нөхөн төлбөрийн үнэлгээний зардал;
 - 3.6.нөхөн төлбөр олгогдсон хэлбэр /дансаар, бэлэн мөнгө, даатгалын зүйлийг орлуулсан эсхүл засварласан зэрэг/;
 - 3.7.даатгалын нөхөн төлбөр олгогдсон этгээд нь даатгуулагч, даатгалд хамрагдсан этгээд, даатгалын нөхөн төлбөр авах эрхтэй этгээд эсэх талаарх болон уг этгээдийн 1.2.а, 1.3.а-д заасан мэдээлэл;
 - 3.8.даатгалын нөхөн төлбөр олгохоос татгалзсан бол татгалзсан огноо, шалтгаан;
 - 3.9.даатгуулагч/хохирогч Хороонд гомдол гаргасан бол Хорооны шийдвэрийн агуулга /даатгагчийн шийдвэрийг үндэслэлтэй гэж үзсэн эсэх/;
 - 3.10.нөхөн төлбөрийн хэмжээнд өөрчлөлт орсон огноо, хэмжээ, шалтгаан.
- 4.Давхар даатгагчид даатгуулсан даатгалын гэрээ, холбогдох нөхөн төлбөрийн бүртгэлд дор хаяж дараах мэдээллийг тусгана. Үүнд:
- 4.1.давхар даатгалын гэрээний дугаар
 - 4.2.давхар даатгагчдын мэдээлэл:
 - а.Оноосон нэр
 - б.Хуулийн этгээдээр бүртгэсэн улсын нэр
 - в.Зээлжих зэрэглэлийн мэдээлэл /Зээлжих зэрэглэл, түүнийг тогтоосон байгууллага, огноо гэх мэт/
 - 4.3.давхар даатгалын гэрээ байгуулсан огноо, даатгалын хамгаалалт эхэлсэн ба дуусах огноо;
 - 4.4.давхар даатгалын гэрээний төрөл /факультатив, трийти эсэх/
 - 4.5.давхар даатгалын гэрээний нөхцөл /Quota share, Excess of loss зэрэг/ болон холбогдох үзүүлэлтүүд /эрсдэлийн хувь, хариуцлагын хязгаар зэрэг/
 - 4.6.даатгалын хугацаа болон даатгалын гэрээний нөхцөл өөрчлөгдөх боломжтой эсэх талаарх мэдээлэл
 - 4.7.давхар даатгалын гэрээний нөхцөл өөрчлөгдсөн огноо;
 - 4.8.давхар даатгалын үндсэн болон нэмэлт эрсдэл, хамгаалалт;
 - 4.9.давхар даатгалын хамгаалалтад багтаж буй даатгалын гэрээ/ гэрээний багцын талаарх мэдээлэл /даатгалын гэрээ байгуулагдсан хугацаагаар, хэлбэр, эрсдэл гэх мэт/
 - 4.10.давхар даатгалын нийт хураамж, хураамж төлөх хуваарь, төлсөн огноо;
 - 4.11.зуучлагчаар дамжуулан давхар даатгалын гэрээг байгуулсан бол зуучлагчийн талаарх 4.3-д заасан мэдээлэл болон шимтгэлийн хувь, хэмжээ
 - 4.12.давхар даатгалын гэрээг цуцалсан бол цуцалсан огноо, хураамжийн буцаалтын хэмжээ, шалтгаан
 - 4.13.давхар даатгагчид нөхөн төлбөрийн нэхэмжлэл хүргүүлсэн огноо, хэмжээ
 - 4.14.давхар даатгагч нөхөн төлбөр олгосон огноо, хэмжээ
 - 4.15.давхар даатгагч нөхөн төлбөр олгохоос татгалзсан бол татгалзсан огноо, шалтгаан

“Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам”-ын гуравдугаар хавсралт

Даатгагчийн даатгалын нөөц сан бүрдүүлэх Дотоод журамд тусгагдах нөхцөл

1. Даатгалын нөөц сан тооцох суурь зарчим, таамаглал, аргачлал ба агуулга (нэр томъёоны тайлбар ба тодорхойлолтыг мөн энэ хэсэгт тусгах);
2. Дата өгөгдөл, мэдээллийн чанарт тавигдах шаардлага, холбогдох зохицуулалт (энэ журмын 2.4-д дурдсан бүртгэлийг үүсгэх, хөтлөх үйл ажиллагаанд тавигдах шаардлага, зохион байгуулалтын тухай мөн тусгана) ;
3. Актуарын стандартын 2.3-д заасан актуарчийн эрх, боломжийг хэрхэн хангах талаарх зохицуулалт (актуарч нөөц сангийн тооцоолол хийхэд шаардлагатай бүртгэл, тайлан, мэдээллийн агуулга, бүтэц, хамрах хугацаа болон тэдгээрийг актуарчид хүргүүлэх хугацаа, албан тушаалтан эсхүл зохион байгуулалтын нэгжийг тодорхойлсон байх) ;
4. Дараах агуулгыг багтаасан даатгалын бүтээгдэхүүнүүдийн талаарх ерөнхий мэдээлэл. Үүнд:
 - даатгалын бүтээгдэхүүн, гэрээнүүдтэй холбогдох даатгалын эрсдэлүүд;
 - даатгалын хугацаа, даатгалын хураамж болон нөхөн төлбөр төлөх хугацаа;
 - даатгалын хураамжийн төлбөрийн зохицуулалт (жил, хагас жил, улирал гэх мэт);
 - энэ журамд заасны дагуу холбогдох даатгалын бүтээгдэхүүнийг бүлэг
 - даатгалын буцаалтыг төлөх аргачлал;
 - холбогдох зардлуудыг тооцох аргачлал.
5. Даатгалын нөөц сан тооцоолоход ашиглах нэмэлт арга, аргачлал, томъёо;
6. Даатгалын нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийг тооцоолох арга, аргачлал, томъёо;
7. Дотоод журмын хэрэгжилтэд хяналт тавих этгээд, аргачлал, давтамж, хариуцлагын арга хэмжээ.

“Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам”-ын дөрөвдүгээр хавсралт

Даатгалын нөөц сангийн актуар тайлангийн загвар

Нүүр хуудас

ДААТГАЛЫН НӨӨЦ САНГИЙН АКТУАР ТАЙЛАН

[ДААТГАЛЫН КОМПАНИЙН НЭР]

[ТАЙЛАНГИЙН ХУГАЦАА]

[тайлангийн огноо]

Тайлангийн агуулга

1. Компанийн актуарчийн талаарх мэдээлэл:

- Компанийн нэр;
- Актуарчийн нэр;
- Оффисын хаяг, утасны дугаар;
- Томилогдсон огноо;
- Хорооноос актуарчийн эрх авсан огноо, тогтоолын дугаар.

2. Тайлангийн зорилго, хамрах хүрээ, хязгаарлалт:

- Зорилго;
- Тайлангийн хамрах хугацаа, даатгалын бүтээгдэхүүн, хэлбэр ба бүтээгдэхүүний бүлгийн мэдээлэл;
- Тайлан гаргах цаг хугацааны болон тайланг бусдад түгээх, ашиглахад тавигдах зэрэг аливаа хязгаарлалт, бусад мэдээлэл.

3. Үндэслэл:

- Тооцоололд тавигдах нийтлэг үндэслэл болон өмнөх үеийн тооцооллоос өөрчлөгдсөн болон нэмэгдсэн зүйлийн талаарх мэдээлэл.

4. Ашиглагдсан мэдээлэл:

- Даатгалын нөөц санг тооцоолоход ашиглагдсан дата өгөгдөл, мэдээлэл, тэдгээрийн эх үүсвэр, хэрхэн баталгаажуулсан болон ямар хугацааны дата

өгөгдөл, мэдээлэл ашиглагдсан талаарх тайлбарыг тусгах (даатгалын үнэлгээ, хураамж, нөхөн төлбөр, зардал зэрэг бүхий л мэдээллийн талаар).

5. Таамаглал, аргачлал:

- Даатгалын нөөц сан, холбогдох үзүүлэлт (хямдруулалтын хүүгийн түвшин, зардлын түвшин гэх мэт) бүрийн хувьд даатгалын хэлбэр, эрсдэл, бүтээгдэхүүний бүлгээр ангилан түүнийг тооцоолох үндсэн таамаглал, аргачлал (загварчлал мөн багтана)-уудаас сонгосон таамаглал аргачлал, уг таамаглал, аргачлалыг сонгох шалтгаан, үндэслэлийн хамт тусгах. Аргачлалуудыг хавсарч ашиглах тохиолдолд мөн үндэслэлээ тайлбарлах.

6. Дүн шинжилгээ, ил тод мэдээлэх зүйлс:

- Таамаглал, аргачлал, загварчлалын тооцооллын хураангуй, оролт, гаралт, үр дүн, хэлбэлзлийн тэдгээр гаралтуудад үзүүлж болзошгүй нөлөөлөл;
- Актуарын стандартын 3.9-д заасан мэдээлэл, тайлбарын хамт;

7. Хавсралт, бусад файлуудтай холбогдох дугаарлалт

- Актуарч тайландаа тооцоололд ашиглагдсан статистик мэдээлэл болон бусад холбогдох файлуудаа хавсаргах бөгөөд эдгээрийг ойлгомжтой хэлбэрээр, дугаарлан тайланд тусгасан байх.